



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.27.1 дэх заалт, "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Алтан Фокус" ХХК-д 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулагдах "Электроник засварын сургалт"-д Мэдээллийн аюулгүй байдал, технологийн албаны тоног төхөөрөмжийн инженер Л.Баярмаа, Б.Баярмаа нарыг хамруулсугай.

2.Сургалтын төлбөрт 1,300,000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгийг зохих журмын дагуу гарган зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3.Ажил үүрэгт нь зохицуулалт хийж, сургалтын үр дүнд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн аюулгүй байдал, технологийн алба (Г.Цэвээнгэрэл)-нд, сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаж, 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн дотор тайлагнахыг суралцагч (Б.Баярмаа, Л.Баярмаа) нарт тус тус үүрэг болгосугай

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0382